



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 07 сарын 24 өдөр

Дугаар А/267

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн байгууллагын магадлан
итгэмжлэх зөвлөлийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.18 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэх зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.
2. Холбогдох хууль, журмын дагуу тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Зөвлөлийн дарга, Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/-т даалгасугай.
4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын "Магадлан итгэмжлэх зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлах тухай" 2023 оны А/359 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтыг хүчингүй болгосонд тооцсугай.

САЙД

Ж.ЧИНБҮРЭН

Эрүүл мэндийн сайдын 2025 оны 07
дугаар сарын 24-ны өдрийн 1207 дугаар
тушаалын хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ЗӨВЛӨЛИЙН
БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга:

Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн
бичгийн дарга

Орлогч дарга:

Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн
тусламжийн бодлогын газрын дарга

Нарийн бичгийн дарга:

Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн
тусламжийн бодлогын газрын тусгай
зөвшөөрөл, магадлан итгэмжлэлийн
асуудал хариуцсан мэргэжилтэн

Зөвлөлийн үндсэн гишүүд:

Эрүүл мэндийн яамны Салбарын
хяналтын газрын дарга

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн
захирал

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий
газрын тусламж үйлчилгээний чанар
төлбөрийн хяналтын газрын дарга

Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн
тусламжийн бодлогын газрын Анхан
шатны тусламж, үйлчилгээ хариуцсан
мэргэжилтэн

Эрүүл мэндийн яамны дэргэдэх
Эмнэлгийн чанар, аюулгүй байдлын
мэргэжлийн салбар зөвлөлийн
төлөөлөл

Хувийн хэвшлийн эрүүл мэндийн
байгууллагын Нэгдсэн холбооны
төлөөлөл

Зөвлөлийн байнгын бус гишүүд:

Хэлэлцэж буй эрүүл мэндийн
байгууллагын тусламж, үйлчилгээний
төрөл, чиглэлээс хамаарч мэргэжлийн
салбар зөвлөл, нийгэмлэгээс төлөөлөл
оролцуулна